



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.09.09 - 09.13

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Зах зээлийн үнэлгээ багатай компаниудын хувьцааны ханш зах зээлийн үнэлгээ өндөртэй компаниудтай харьцуулахад илүү өндөр өсөлт үзүүлжээ.

S&P 500 индексийн сагсанд багтах материал, санхүү болон үйлдвэрлэлийн салбарын компаниудын хувьцааны ханш хамгийн ихээр өслөө. Урт хугацаат бондын өгөөж нэмэгдсэнтэй холбоотойгоор санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол материал болон аж үйлдвэрлэлийн салбар худалдааны маргааны нааштай үр дүнгүүдээс үүдэн өсөлттэй байв.

АНУ болон БНХАУ-ын эрх баригчид худалдааны маргааны асуудлын хүрээнд, буулт хийж эхэлсэн нь энэхүү өсөлтийн шалтгаан болов. БНХАУ АНУ-ын зарим бараа бүтээгдэхүүнүүдийг татвараас чөлөөлсөн ба үүний хариуд АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп твиттер хуудсанддаа БНХАУ-ын бараа бүтээгдэхүүнд ногдуулсан татварыг ирэх 10-р сарын 1-ний өдрөөс 5 хувиар нэмэх шийдвэрийн хэрэгжиж эхлэх хугацааг хоёр долоо хоногоор хойшлууллаа хэмээн мэдэгдлээ.

Хоёр тал худалдааны маргааныг шийдвэрлэх сонирхолтой байгаа ч шинжээчдийн үзэж байгаагаар 2020 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн гарах хүртэл тус асуудалд бодит үр дүн гарахгүй юм.

Европ: Европын төв банкнаас Евро бүсийн эдийн засгийг дэмжих зорилгоор авах арга хэмжээгээ танилцуулсантай холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Европын төв банк хадгаламжийн хүүгээ -0.4%-аас -0.5% болгон бууруулжээ. Мөн мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэх бодлогоо дахин эхлүүлэх зорилгоор 11-р сарын 1-ий өдрөөс эхлэн сар бүр 20 тэрбум еврогийн үнэт цаас худалдан авах юм. Европын төв банкны Ерөнхийлөгч ноён Марио Драги энэхүү алхмын үндсэн шалтгаан нь бүс нутгийн инфляцын төвшин хэт бага байгаатай холбон тайлбарлажээ.

Их Британи улсын Парламентаас 10-р сарын 31-ны өдөр Европын холбооноос хэлэлцээргүй гарахыг эсэргүүцэн тухайн хугацаанд хэлэлцээрт хүрч чадаагүй тохиолдолд Их британи улс Засгийн Газраараа дамжуулан Европын холбооноос гарах хугацааг хойшлуулах тухай хуулийг баталжээ. Үүнтэй холбоотойгоор фүнтийн ханш ам.долларын эсрэг чангарсан байна.

Япон: Япон улсын 2019 оны 2-р улирлын ДНБ-ий өсөлт таамаглаж байснаас доогуур буюу 1.3%-ын өсөлт үзүүлжээ. Тэгсэн хэдий ч, АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргааны асуудал нааштай шийдэгдэх болсонтой холбоотойгоор Японы хөрөнгийн зах зээлийн индексүүд өссөлттэй хаагдлаа.

Япон болон Өмнөд Солонгос улсуудын харилцаа муу хэвээр байна. Өнгөрөгч долоо хоногт Өмнөд Солонгос улсын эрх баригчид Дэлхийн худалдааны байгууллагад Япон улсын тухай албан ёсны гомдол гаргасан байна. Дэлхийн худалдааны байгууллага маргааныг таслах шийдвэр гаргахаас өмнө тус улсууд хоорондоо шийдэлд хүрэх гэж хичээх шаардлагатай байгаа юм.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь БНХАУ-ын эрх баригчид худалдааны маргааныг шийдвэрлэхэд нөлөөлөх томоохон алхам хийж, эдийн засгийг эрчимжүүлэх нэмэлт арга хэмжээ авах хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд нэмэгдсэнтэй холбоотой.

БНХАУ-ын 8-р сарын эдийн засгийн үзүүлэлтүүд сул гарсан нь Төв банк эдийн засгийг идэвхжүүлэх бодлого хэрэгжүүлэх шалтгаан болно гэж шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,477.47	-0.77% ▼
Dow Jones	АНУ	27,219.52	1.58% ▲
S&P 500	АНУ	3,007.39	0.96% ▲
Nasdaq	АНУ	8,176.71	0.91% ▲
S&P/TSX	Канад	16,682.42	0.89% ▲
FTSE 100	Их Британи	7,367.46	1.17% ▲
S&P/ASX 200	Австрали	6,669.20	0.33% ▲
Nikkei 225	Япон	21,988.29	3.72% ▲
Hang Seng	Хонг Конг	27,069.34	1.42% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.32
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.35
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.33
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.95
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.81
DBM' 2023	USD	7.250%	103.56
TDBM' 2020	USD	9.375%	102.70
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	99.55

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.025	-0.04 ▼
Libor 3M	2.139	0.00 ▼
Libor 6M	2.070	0.00 ▼
Libor 1YR	2.049	-0.02 ▼
US 2YR Bond	1.800	0.03 ▲
US 3YR Bond	1.758	0.05 ▲
US 5YR Bond	1.751	0.04 ▲
US 10YR Bond	1.896	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.09.13	Өөрчлөлт
USD	2,670.87	-0.03% ▼
CNY	377.27	0.48% ▲
EUR	2,962.93	0.56% ▲
RUB	41.42	1.99% ▲
KRW	2.27	1.34% ▲
JPY	24.74	-1.00% ▼
CAD	2,020.17	-0.39% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,504.81	-0.13% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	17.44	-4.04% ▼
Зэс	USD/lb.	269.95	2.49% ▲
Нүүрс	USD/MT	70.47	1.25% ▲
WTI газрын тос	USD/bbl.	54.85	-2.95% ▼
Brent газрын тос	USD/bbl.	60.22	-2.14% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VII	7.70%
Бодлогын хүү	2019. VII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VII	10.99%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	11.44%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VII	4.98%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	16.99%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 46 компанийн 204.0 сая төгрөгийн 1,001,510 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Cор” /SOR/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 989.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Дархан хөвөн” /DAH/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 8,500.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

9-р сарын 13-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,480.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,477.47 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.77%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	204.0
Зах зээлийн үнэлгээ	2,480,805.6

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,477.47	-0.77% ▼
MSE I индекс	9,018.73	-0.35% ▼
MSE II индекс	7,794.90	-2.31% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	142,675	39,923,039
АПУ	77,405	39,323,057
Ард санхүүгийн нэгдэл	22,546	32,552,521
Инвескор ББСБ	6,415	12,560,555
Таван толгой	1,806	11,913,545

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Сор	989.00	15.00% ▲
Хай би ойл	60.03	14.17% ▲
Багануур	1,100.00	7.84% ▲
Талх чихэр	18,000.00	5.88% ▲
Монгол шуудан	608.50	2.96% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан хөвөн	8,500.00	-15.00% ▼
Өндөрхаан	1,635.00	-14.98% ▼
Материалимпекс	6,000.00	-14.29% ▼
Ремикон	22.50	-10.25% ▼
Жуулчин дүти фрий	100,300.00	-8.82% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	110,615,326
Ти Ди Би Капитал	65,686,116
БиДиСек	57,710,207
Голомт Капитал	48,850,249
Стандарт инвестмент	35,726,609

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	503.26	535,560
Таван толгой	6,540.00	344,430
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	284.93	222,277
Инвескор ББСБ	2,000.00	143,456

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.09.09-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Ард кредит ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Ард кредит ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9-р сарын 7-ны өдрийн 2019/23 тоот тогтоолын дагуу эчнээ санал хураалт явуулахаар болсон байна.

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал: “Ард Кредит ББСБ” ХК-ийн дүрмийг шинэчилсэн найруулгаар батлах

Эчнээ санал хураалтанд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2019 оны 9-р сарын 26-ны өдөр

Эчнээ санал хураалт явуулах хугацаа: 2019 оны 10-р сарын 01-ний өдрөөс 11-р сарын 11-ний өдөр хүртэл

Эчнээ санал хураалтын материалтай танилцах: 2019 оны 11-р сарын 11-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09-18 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар хаягаар эсвэл цахимаар ardcredit.shareholdersmeeting@gmail.com хаягаар саналаа ирүүлэх боломжтой.

Зохион байгуулах комисс: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар, Утас: 77003322, 80114871

Хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан өөрийн харилцдаг үнэт цаасны компанид хандан санал авах хуудас бөглөх замаар эчнээ санал хураалтанд оролцох боломжтой.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Сүү” ХК ногдол ашиг тараахаар боллоо

“Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9-р сарын 09-ний өдрийн №06 тоот тогтоолоор компанийн 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3 төгрөг 33 мөнгө буюу нийт 1,143,416,667 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг тус компанийн 2019 онд хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр буюу 2019 оны 4-р сарын 05-ны өдрөөр тогтоож, 2019 оны 9-р сарын 9-ний өдрөөс 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн хооронд “ҮЦТХТ” ТӨХК-аар дамжуулан тараахаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Бэрх уул” ХК-ийн гол хувьцаа эзэмшигч нь ээлжит бус хурал хийх санал гаргав

“Бэрх уул” ХК-ийн хамгийн том хувьцаа эзэмшигч “Khanate Resource Holding S.A.R.L” нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийх санал гаргаснаар 10-р сарын 18-нд хуралдах болсон талаар компаниас мэдээлэв.

“Khanate Resource Holding S.A.R.L” нь тус компанийн нийт хувьцааны 51.82%-ийг эзэмшдэг бөгөөд 4 том хувьцаа эзэмшигчийн нэг юм. “Бэрх уул” компани нь МХБ-ийн хувьцааны төвлөрөл өндөртэй компанийн нэг бөгөөд компанийн хувьцааны 99.66% нь дээрх том хөрөнгө оруулагчдад төвлөрсөн байдаг.

Ээлжит бус хурлаар одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр сонгох аж.

Эх сурвалж: MarketInfo.mn

“Говь” ХК АНУ-д охин компани байгуулахаар болов

“Говь” ХК гадаад зах зээлд үйл ажиллагаа, борлуулалтаа тэлэх зорилгоор АНУ-д охин компани байгуулахаар болжээ. Уг охин компани нь АНУ-ын Калифорни мужын Лос Анжелес хотод байршин үйл ажиллагаа явуулах юм байна.

МУ-ын Ерөнхийлөгч Х.Баттулга-ын 7-р сард АНУ-д хийсэн айлчлалын үеэр “Говь” компанийн Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан тус улсад төлөөлөгчийн газраа нээсэн талаар мэдэгдэл хийж байсан.

АНУ нь дэлхийн ноолуурын салбарын 2 дахь том хэрэглэгч бөгөөд нийт дэлхийн зах зээл 2018 оны байдлаар 3.2 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа.

Мөн АНУ-ын Конгресс “Гуравдагч улсын худалдааны хууль”-ийг хэлэлцэх хүлээлттэй байгаа. Уг хууль батлагдснаар манай улсаас экспортлох ноолууран бүтээгдэхүүн тус улсад татваргүй орох боломж бүрдэнэ.

Энэ мэтчлэн зах зээлийн боломж, үйл ажиллагаагаа тэлэх бодлогын хүрээнд дээрх алхамыг хэрэгжүүлж байгаа ажээ.

“Говь” компанийн хувьд 2018 оны нийт борлуулалтын 36% буюу 61.6 тэрбум төгрөгийг гадаад зах зээлийн борлуулалт эзэлж байсан бол энэ жил гадаад борлуулалтаа 34%-аар нэмэгдүүлэхээр төлөвлөөд ажиллаж байгаа билээ.

Эх сурвалж: MarketInfo.mn



“Лэндмн ББСБ” ХК үйл ажиллагаандаа зориулан зээлийн эх үүсвэр татна

“Лэндмн ББСБ” /MSE:LEND/ компани зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор дотоодын нэр бүхий арилжааны банкуудаас зээл авахаар болжээ. Үүнтэй холбоотойгоор ТУЗ-өөс холбогдох шийдвэрийг гаргаснаа мэдээлэв.

Зээлийн тухайд:

- Голомт банкнаас 3 тэрбум төгрөг хүртэлх зээлийн шугамыг 2 жилийн хугацаатай

- ХХБанкнаас 660,000 ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийг 2 жилийн хугацаатай

- Капитрон банкнаас 3 тэрбум төгрөг хүртэлх зээлийн шугамыг 2 жилийн хугацаатай

- Улаанбаатар хотын банкнаас 3 тэрбум төгрөг хүртэлх зээлийн шугамыг 2 жилийн хугацаатай

Энэ оны 2-р улиралд компани 8 сая ам.долларын эх үүсвэрийг Худалдаа хөгжлийн банк болон Капитрон банкинд хадгалуулж, уг хадгаламжийг барьцаалсан төгрөгийн зээл авахаар шийдвэрлэж байсан.

Түүнчлэн үйл ажиллагааны чиглэлдээ “Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх” гэсэн үйл ажиллагааг нэмэхээр болжээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нүүрсний экспорт дээд амжилт тогтоов

Оны эхний найман сарын байдлаар Монгол улсын нүүрсний экспорт 25 сая тоннд хүрсэн тухай Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд 5.2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Сарын дүнгээр авч үзвэл, өнгөрсөн наймдугаар сард 4 сая 125 мянган тонн нүүрсний экспорт хийж түүхэн дээд амжилт тогтоолоо. Харин мөнгөн дүнгийн хувьд 15.6%-ийн өсөлттэй буюу 2.135 тэрбум ам.доллартай тэнцэж байна. Гэхдээ энэ онд нүүрсний экспорт 42 сая тонн байхаар улсын төсөвт тооцож буй төлөвлөгөө биелэхэд хүндрэлтэй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр, оны эхний найман сарын байдлаар манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.5 тэрбум ам.долларт хүрч 11.9%-иар өсчээ. Үүнд экспорт 5.4 тэрбум ам.доллар, импорт 4.1 тэрбум ам.долларыг эзэлсэн байна. Тодруулбал, экспорт өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 15.3%, импорт 7.6%-аар тус тус өслөө. Гадаад худалдаа 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеийнхээс 426.6 сая ам.доллаар нэмэгджээ.

Нийт экспортод эзлэх эрдсийн экспортын хэмжээ 4.44 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 11.5%-аар нэмэгдсэн байна. Энэ дундаа нүүрсний экспорт орлогын дүнгээр тэргүүлж буй бол зэс хоёрдугаарт эрэмбэлэгдэв.

Зэсийн баяжмалын экспортын тухайд оны эхний найман сарын байдлаар нийтдээ 981.9 мянган тоннд хүрч, мөнгөн дүнгээр 1.328 тэрбум ам.долларт хүрлээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад жингээр 2.3%-аар өссөн бол үнийн дүнгийн хувьд ижил хэмжээнд хадгалагдаж байна. Харин цэвэр зэсийн хувьд экспортын хэмжээ 6.28 мянган тоннд хүрч, мөнгөн дүнгээр 36.9 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд 30.8%-аар, үнийн дүнгээр 37.9%-аар тус тус буурсан дүн юм.

Төмрийн хүдрийн тухайд, эрдсийн экспортод гуравдугаар байр эзэлж байна. Оны эхний найман сард уг түүхий эдийн экспорт жингээр 5.55 сая тоннд хүрсэн нь 21%-ийн өсөлтийг, үнийн дүнгээр 378.6 сая ам.доллар нь 80%-ийн өсөлтийг харууллаа.

Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспорт мөн хугацаанд 7.5 тонн буюу 344 сая ам.доллартай тэнцсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгийн хувьд 2.4 дахин, жингийн хувьд 2.2 дахин өссөн дүнтэй гарчээ. Гэхдээ Монголбанкны мэдээллээр, оны эхний найман сарын хугацаанд Төв банкны алт худалдан авалт 9.6 тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 21%-аар буурсан байгаа юм.

Түүхий газрын тосны экспорт 4.29 сая баррельд хүрч, 240.9 сая ам.доллартай тэнцжээ. Ингэснээр жингийн хувьд 2.2%, үнийн дүнгийн хувьд 16%-аар тус тус буурсан дүнтэй гарсан байна.

Жоншны хүдэр, баяжмалын тухайд оны эхний найман сард 420.9 мянган тонныг гадагш нийлүүлж, 132.38 сая ам.доллартай тэнцсэнээр жингийн хувьд 45.6%, орлогын тухайд 36.5%-аар тус тус нэмэгджээ.

Цайрын хүдэр, баяжмалын экспортыг авч үзвэл, мөн хугацаанд нийтдээ 90.7 мянган тоннд бүтээгдэхүүн нийлүүлж, 132.27 сая ам.долларын орлого олсон нь жингийн хувьд 11.6%-аар өссөн ч үнийн дүнгийн хувьд 4.5%-аар буурлаа.

Молибденийн баяжмалын экспорт оны эхний найман сард 3.7 мянган тоннд хүрч 32.7 сая ам.долларт хүрснээр жингээр 5.6%-аар буурсан ч орлогын хувьд 3.3%-аар нэмэгджээ.

Хар тугалгын хүдэр, баяжмалын экспортын хувьд оны эхний найман сарын хугацаанд 15.8 орчим мянган тонн бүтээгдэхүүн нийлүүлж, 34 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь жингийн хувьд 27.6%, орлогын дүнгээр 7.8%-аар тус тус өссөнийг илтгэнэ.

Гянтболдын экспортын тухайд 373.4 тоннд хүрч 4.13 сая ам.долларын орлого олсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд ялимгүй буурсан бол, үнийн дүнгийн хувьд 3.1%-аар буурсан дүнтэй гарлаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



Метал хийц боловсруулах төвийн нээлт боллоо

Дэлхийд алдартай "Катерпиллар"-ын Монгол дахь албан ёсны дилер "Вагнер Ази Тоног Төхөөрөмж" ХХК өөрийн төв байрандаа Метал хийц боловсруулах төвийн нээлтээ хийлээ. Монголын метал хийц боловсруулалтын салбарт шинэ хуудсыг нээсэн тус төв нь орчин үеийн дэвшилтэт технологи бүхий, анхны бүрэн компьютержсон токарийн цехийг бүрдүүлж чадсанаараа онцлог ажээ. Монгол Улсад өнөөдрийг хүртэл Оросын токарийн цехүүд үйл ажиллагаа явуулж ирсэн бол цаашид дэлхийн технологийн ололт амжилтаа ашиглан засварын үйл ажиллагааг төгс гүйцэтгэх боломжтой боллоо хэмээн "Вагнер Ази Тоног Төхөөрөмж" компанийн удирдах ажилтнууд хэлж байв.

Олон улсын жишигт хүрсэн хамгийн сүүлийн үеийн энэхүү төвөөр дамжуулан хүнд үйлдвэрийн олон ажлыг богино хугацаанд хийж гүйцэтгэх боломжтой болж байгаа аж. Энэ төв нь 2019 онд хийж бүтээж буй хамгийн том ажил гэдгийг тус компанийн Гүйцэтгэх захирал Кэлвин Кокинэн нээлтийн үгэндээ онцолж байсан.

Метал хийц боловсруулах төв нь цахилгаан станц болон барилгын, цемент, бетон зуурмагийн, уул уурхай, замын компаниуд болон бусад төмөр, метал хийцийн боловсруулалт хийх шаардлагатай хүнд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд зориулагдсан гэж хэлж болно. Нээлтийн үйл ажиллагааны үеэр "Вагнер Ази Тоног Төхөөрөмж" болон түншлэгч байгууллагуудын дунд 38,5 тэрбум төгрөгийн техник худалдан авах, үйлчилгээ үзүүлэх гэрээг холбогдох албаны хүмүүс зурлаа. Нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулдаг зургаан компанийн нэг болох "Багануур" ХК Агрегат засварын төвөөр үйлчлүүлэх гэрээг мөн үзэглэсэн.

Нээлтийн үйл ажиллагааны дараа зочид тус төвийн үйл ажиллагаатай танилцсан юм. Метал гагнуурын (Metal spray) цацаж гагнадаг робот, элсэн ба шилэн өнгөлгөө хийх зориулалттай элсээр шүршигч, хэвтээ фрезерийн суурь машин, хөдөлгүүрийн блок зорох машин зэрэг олон тоног төхөөрөмжөөр тус төв бүрэн тоноглогджээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 8-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 8-р сарын эцэст 20.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 185.8 (0.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.0 (17.4%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 8-р сарын эцэст 925.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 9.3 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1.8 (0.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 8-р сарын эцэст 18.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 23.0 (0.1%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.3 (14.5%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 8-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 19.8 (1.0%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 545.6 (39.9%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 8-р сард 2 670.54 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар, өмнөх сараас 0.3 хувиар тус тус суларсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 8-р сард 378.16 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар суларч, өмнөх сараас 2.3 хувиар чангарсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 8-р сард 40.66 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар суларч, өмнөх сараас 3.3 хувиар чангарсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.9 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 549.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 8-р сард 841.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 293.4 (25.9%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 826.8 тэрбум төгрөг болж, 35.3 (4.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.3 хувийг татварын орлого, 8.2 хувийг татварын бус орлого, 10.0 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.5 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2019 оны эхний 8 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 920.3 (17.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 532.1 (11.7%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 460.4 (69.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 80.1 хувь, хөрөнгийн зардал 17.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.1 хувийг эзэлж байна.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 760.6 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 192.0 сая америк доллараар буурчээ.

Урсгал данс 816.0 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.0 тэрбум америк доллар, анхдагч орлогын данс 843.3 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 7 сард 55.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.7 (18.6%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 776.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 107.5 (12.2%) сая америк доллараар буурчээ.

Төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 7 сард 235.3 сая америк долларын алдагдалтай байсан бол 2019 оны эхний 7 сард өмнөх оны мөн үеэс 155.3 сая америк доллараар буурч, 79.9 сая америк долларын алдагдалтай гарчээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны эцсээс 5.4 хувь, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8-р сард өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 13.3 хувь (мах, махан бүтээгдхүүний дэд бүлгийн үнэ 32.0 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 16.3 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8-р сард өмнөх оны эцсээс 5.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь (мах, махан бүтээгдэхүүн 32.8 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 8-р сард өмнөх сараас 0.3 хувиар өсөхөд, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 9.7 хувь, зочид буудал зоогийн газрын бүлгийн үнэ 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2019 оны 8-р сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 33.1 хувь буюу 114 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 12.5 хувь буюу 43 бараа, үйлчилгээний үнэ буурч, 54.4 хувь буюу 187 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 48 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо